



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ

Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ

2019 оны 9-р сар




МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 18,976 **-2.3%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



МХБ-1 индекс, 9,016 **-2.1%**, МХБ-2 индекс 7,814 **-3.8%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



Олон улсын индексүүд

Индекс	2019.07.31	2019.08.30	Өөрчлөлт, %
DJIA (US)	26,118	26,916	3.1%
S&P 500 (US)	2,927	2,977	1.7%
Nikkei 225 (JP)	20,690	21,760	5.2%
Hang Seng (HK)	25,725	26,092	1.4%
DAX 30 (DE)	11,939	12,428	4.1%
SMI (CH)	9,896	10,078	1.8%

Валютын ханш

Валют	2019.07.31	2019.08.30	Өөрчлөлт, %
USD	2,672.00	2,667.21	-0.2%
EUR	2,949.35	2,916.46	-1.1%
JPY	25.1	24.73	-1.5%
RUB	40.19	41.26	2.7%
CNY	374.11	374.1	0.0%
KRW	2.21	2.23	0.9%

Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	1.8	43%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,477.1	-0.7%
Бүртгэлтэй компани	199	199
Арилжаалагдсан хувьцаа	67	70
Арилжаалагдсан өдөр	22	23

Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2019.08.31	2019.09.30	Өөрчлөлт, %
UID	670.00	807.18	+20%
SOR	977.00	1,135.00	+16%
DBL	171.00	196.65	+15%
BHL	345.00	396.75	+15%
ADB	68.27	75.25	+10%

Хамгийн их бууралттай

Хувьцаа	2019.08.31	2019.09.30	Өөрчлөлт, %
AOI	1,700	1,100	-35%
ERS	9,000	6,510	-28%
MSH	350	270	-23%
MBW	344	285	-17%
MRX	24	20	-17%

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

"СҮҮ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Сүү" ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 9-р сарын 9-ний өдрийн №06 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 3.33 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2019 оны 4-р сарын 5-ны өдрөөр тогтоож, 9-р сараас 12-р сарын хооронд ҮЦТХТ-өөр дамжуулан тараах юм байна.

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН" ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ӨРӨМДЛӨГИЙН 2-Р ШАТНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ЭХЛҮҮЛЭЭ

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD | MSE:ERDN) нь Хөндий Алтны Төсөл дээр 2019 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн 2-р үе шатыг эхлүүлсэн байна. Тус компани нь 2019 оны 2-р улиралд хийсэн өрөмдлөгийн үр дүнд 5.9г/т агууламж бүхий 112 метр гүнд өрөмдлөг хийж, Баян Хөндий ордын төв хэсэгт, дөт гүнд алтны өндөр агууламж бүхий бүс үргэлжилж буйг баталгаажуулсан бөгөөд энэхүү шинээр эхлүүлж буй өрөмдлөгийн хөтөлбөрөөр тус бүсийг үргэлжлүүлэн шалгана гэж мэдэгджээ.

ҮЦТХТ-Д 9-Р САРД НЭЭГДСЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

"ҮЦТХТ"-д 9-р сард нийт 6,000 данс нээгдсэнээс 4,519 данс шинээр, 1,481 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 5,995 дотоодын иргэн, 2 гадаадын иргэн, 3 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

"АТАР ӨРГӨӨ" ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ ЗАРЛАГДЛАА

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.1.1-д Компанийн хувьцаа эзэмшигч дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран, эсхүл хувьцаа эзэмшдэггүй этгээд тухайн компанийн хувьцааг бүхэлд нь, эсхүл хувьцааны хяналтын багцаас дээш хувийг худалдан авахаар сайн дурын үндсэн дээр санал гаргана гэж заасны дагуу "Таван Богд Инвест" ХХК нь "Атар Өргөө" ХК-ийн 174,136 ширхэг энгийн хувьцаа буюу нийт энгийн хувьцааг 100 хувь худалдан авах саналыг нийтэд гаргалаа. Үүнд:

- Санал болгож буй үнэ: 60,200 төгрөг
- Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2019/09/26
- Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2019/10/31-ний 13:00 цаг
- Хувьцааны худалдан авах төлбөрийг гүйцэтгэх хугацаа: 2019/11/01
- Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: 0 ширхэг буюу 0%
- Худалдах санал хэрхэн өгөх вэ: өөрийн үйлчлүүлдэг брокерт хандаж захиалга өгөх. Дэлгэрэнгүй мэдээллийг манай 70114433 утсаар авна уу.

"АРД КРЕДИТ ББСБ" ХК ТАЙЛАНГАА НИЙТЭЛЖЭЭ

2019 оны 3-р сард олон нийтээс 5.2 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн "Ард Кредит ББСБ" ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг 2019 оны 9-р сарын 13-



Хамгийн их арилжигдсан

Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн, сая төг	Эзлэх %
AARD	642,881	880.4	33.9%
LEND	9,504,046	489.1	18.8%
INV	183,642	355.5	13.7%
GOV	732,074	206.6	8.0%
APU	237,862	120.1	4.6%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их өссөн, тэрбум төгрөгөөр

Компани	2019.09.30	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
MIK	298.0	14.3	+5.0%
MNP	64.1	5.4	+9.2%
UID	29.7	5.0	+20.5%
AARD	40.2	3.2	+8.7%
SHV	34.9	3.0	+9.2%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их буурсан, тэрбум төгрөгөөр

Компани	Нэгж үнэ, ₮	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
TTL	342.3	15.8	-4.4%
BUK	50.3	6.2	-11.0%
INV	132.9	4.8	-3.5%
MFC	24.5	3.7	-13.1%
MBW	16.1	3.3	-17.2%

ны өдрөөр дараах байдлаар зарцуулсан тухай тайланг МХБ-д ирүүлсэн байна. Үүнд:

- Зээл олголт: 4.9 тэрбум төгрөг;
- Маркетингийн зардал: 205.5 сая төгрөг;
- Мэргэжлийн байгууллагуудын төлбөр, шимтгэл, хураамж: 276.5 сая төгрөг;
- Хэвлэл танилцуулганы зардал: 54.4 сая төгрөг.

"ТҮМЭН ШУВУУТ" ХК ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТАА ТАЙЛАГНАВ

Мөн 2019 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 10.0 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн "Түмэн шувуут" ХК-ийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт 2019 оны 8-р сарын байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

- Өндөглөгч тахианы аж ахуйг өргөтгөх: 1.8 тэрбум төгрөг;
- Шинээр 200,000 шувууны аж ахуй байгуулах: 842 сая төгрөг;
- Сангасны бордооны үйлдвэр байгуулах: 1.1 тэрбум төгрөг;
- Усалгаатай тариаланг өргөжүүлэх-889.2 сая төгрөг.

Та өөрөө гар утаснаасаа шууд арилжаа хийхийг хүсвэл манай "Цахим данс" системд бүртгүүлээрэй.

"ЦАХИМ ДАНС" СИСТЕМ



<https://dbx.standardinvestment.mn/>

Standard Investment



Мөн гар утасны аппликэйшн татан авч, онлайн арилжаа хийж, дансаа хянах боломжтой.



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



МӨНГӨ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 8-р сарын эцэст 20.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 185.8 (0.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.0 (17.4%) их наяд төгрөгөөр өссөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 8-р сарын эцэст 925.7 тэрбум болжээ.


Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018.08	2019.08*
Мөнгөний нийлүүлэлт, M2	17,441	20,475.7
Жилийн өөрчлөлт, %	20.1	117.4
Сарын өөрчлөлт, %	1.3	0.9
Нийт хадгаламж	12,058.7	13,794.6
Жилийн өөрчлөлт, %	22	114.4
Сарын өөрчлөлт, %	0.3	0.2
Төгрөгийн хадгаламж	9,417.8	10,850.3
Жилийн өөрчлөлт, %	26	15.2
Сарын өөрчлөлт, %	0.6	-0.4
Валютын хадгаламж	2,640.9	2,944.3
Жилийн өөрчлөлт, %	9.4	11.5
Сарын өөрчлөлт, %	-0.5	0.6

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 8-р сарын эцэст 18.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 23.0 (0.1%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.3 (14.5%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 8-р сарын эцэст 982.4 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 103.8 (11.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 36.1 (3.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 7-р сарын эцэст 12.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 8.0 (0.1%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.8 (17.7%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг 31. Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг



УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 6.9 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 549.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 8-р сард 841.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 293.4 (25.9%) тэрбум төгрөгөөр буурч, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 826.8 тэрбум төгрөг болж, 35.3 (4.5%) тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг 33. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 760.6 сая ам. долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 192.0 сая ам. доллараар буурчээ. Урсгал данс 816.0 сая ам. долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.0 тэрбум ам. доллар, анхдагч орлогын данс 843.3 сая ам. долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 36. Бараа болон үйлчилгээний худалдааны тэнцэл, сараар, сая америк доллараар



ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2019 оны эхний 8 сард дэлхийн 143 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 9.5 тэрбум ам. доллар, үүнээс экспорт 5.4 тэрбум ам. доллар, импорт 4.1 тэрбум ам. долларт хүрлээ. Харин 2019 оны 8-р сард экспорт 815.6 сая ам. доллар, импорт 584.0 сая ам. доллар болж, өмнөх сараас экспорт 183.1 сая ам. доллараар өсөж, импорт 29.4 сая ам. доллараар буурсан байна.

Зураг 37. Экспорт, импорт, тэнцэл, сараар, сая америк доллар




Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.0 (11.9%) тэрбум ам. доллар, үүнээс экспорт 715.8(15.3%) сая ам. доллараар, импорт 289.2 (7.6%) сая ам. доллараар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2018 оны 8 сард 869.2 сая ам. долларын ашигтай гарч байсан бол 2019 оны 8 сард өмнөх оны мөн үеэс 426.6 сая ам. доллараар өсч, 1.3 тэрбум ам. долларт хүрчээ.



ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.3 хувь, өмнөх оны эцэсээс 5.4%, өмнөх оны мөн үеэс 8.9%-р өссөн байна.

Зураг 38. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар =100%), хувь



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 13.3 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 32.0 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 9.3 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 12.1 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 16.3 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
6-р хороо, Бага тойруу 24,
Монреимпекс ХХК-ийн байр,
2-р давхар, 201 тоот

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

©2019 *Стандарт инвестмент ҮЦК*